


1. Эрдэнэ зуу хийд 1586 онд байгуулагдаж, Тэгвэл уг хийд ямар хотын суурин дээр баригдсан бэ?
 А. Улаанбаатар хот
 В. Шанду хот
 С. Хархорум хот
 D. Хар балгас хот
2. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү.
 1686 онд Анхдугаар богд Жавзандамба буюусоёмбо үсэг зохиожээ.
 А. Зая бандид Намхайжамц
 В. Өндөр гэгээн Занабазар
 С. Аюуш гүүш
 D. Да лам Цэрэнчимэд
3. Бурхны шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор монголчуудын амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?
 А. Хайрцаг үйлдэж сахиус хийж сугандаа зүүгээд унтах, хэвтэх, идэх уухдаа биеэсээ салагддаггүй
 В. Эсгий ширж хээ угалзаар чимэглэх болсон
 С. Гэрийн тооно авсаархан болж, нүүх, тээвэрлэхэд улам тохиромжтой болсон
 D. Жилийн дөрвөн улирал, аж байдалдаа зохицсон нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон
4. Уг сурвалжид монголчуудын ямар соёлын тухай өгүүлж байна вэ?
 “...Өдөрт хорь гучин газар давхиулж жаахан хөлс жаахан хөлс гаргаж түүний өмнө хоёр хөлийг нь тушиж, үсэрч харайлгалгүй бас уяад сайн идүүлж сургахгүй өдөр бүр үдээс хойш болтол, эсвэл оройгоос үүр цайтал уясны хойно бэлчээрт тавина...”
 (Г.Сүхбаатар, Л.Жамсран “Монголын түүхийн дээж бичиг”)
 А. Монголчуудын эдийн соёл
 В. Монголчуудын нүүдэл хийх соёл
 С. Монголчуудын бичгийн соёл
 D. Монголчуудын адуу эдлэх соёл
5. XV-XVII зуунд Мин улсад “Хориотой хот” хэмээн нэрлэгддэг эзэн хааны их ордон баригдав. Энэ нь одоогийн аль хотод баригдсан бэ?
 А. Хөх хот
 В. Шанхай хот
 С. Эрээн хот
 D. Бээжин хот
6. Таж Махалыг хайрт хатан Мумтаз Махалд зориулан бариулсан Их Моголын хаан хэн бэ?
 А. Мухамед
 В. Шах Жахан
 С. Бабур
 D. Акбар
7. Газарзүйн зурагт 3 тоогоор ямар нутаг дэвсгэрийг харуулсан байна вэ?



- А. Өвөр Монгол
 В. Шинжаан
 С. Халх
 D. Төвөд

8. 1842 оны 8-р сарын 29-нд Нанжин хотод анхны тэгш бус гэрээ буюу “Боолчлолын гэрээ”-нд гарын үсэг зурав. Уг үйл явдлын хэддүгээр зуунд болон одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
 - A. XIX зуунд, 184 жилийн өмнө
 - B. XVIII зуунд, 3868 жилийн өмнө
 - C. XVIII зуунд, 184 жилийн өмнө
 - D. XIX зуунд, 3868 жилийн өмнө
9. Христос сүм хийд нь ёс суртахууны хатуу чанга хэм хэмжээ, зан суртахууныг номлогч байх ёстой хэмээн хэн тунхагласан бэ?
 - A. Иохан Тецель
 - B. Мартин Лютер
 - C. Жан Кальвин
 - D. Уильям Гарвей
10. Сэргэн мандалтын эхэн үе аль нь вэ?
 - A. XV-XVI зуун
 - B. XIV-XV зуун
 - C. XIII-XIV зуун
 - D. XII-XIII зуун
11. “Дон Кихот” романаа шоронд байхдаа хэн туурвисан бэ?
 - A. Боккаччо
 - B. Данте
 - C. Шекспир
 - D. Сервантес
12. XVIII зуунд Их Британд эрээн даавууны эрэлт хэрэглээ ихэссэн тул Манчестрийн даавууны үйлдвэрлэлийг дэмжихийн тулд Засгийн газар ямар арга хэмжээ авсан бэ?
 - A. Энэтхэг, Хятадаас бөс даавуу авчрахыг хориглосон
 - B. Засгийн газар их хэмжээгээр зээл өгөх болсон
 - C. Даавуун хувцас өмсөхөө больсон
 - D. Гадаадаас ажиллах хүчин авчруулах болсон
13. Доорх газрын зурагт Португалын адмирал Васко да Гамаг-н далайн аяллын маршрутыг ямар өнгөөр зурсан байна вэ?



- A. Улаан өнгө
- B. Хөх өнгө
- C. Цэнхэр өнгө
- D. Шар өнгө

14. АНУ-ын зохион бүтээгч Томас Эдисон зохион бүтээсэн бүтээл аль нь вэ?




A. Нисдэг машин



B.



C.



D.

15. Дараах улсуудын колоничилсон улсуудыг зөв холбосон нь аль вэ?

1. Австрали, Энэтхэг, Хойд Америк	a. Испани
2. Мексик, Перу, Чили	b. Англи
3. Бразил, Сеута, Макао	c. Португал

A. 1a, 2b, 3c

B. 1b, 2c, 3a

C. 1b, 2a, 3c

D. 1a, 2c, 3b

16. Доорх зурагнуудыг ашиглаж асуултад хариулаарай.

БРИТАНИЙН ЗЭЭНТ ГҮРЭН /1920 он/



МОНГОЛЫН ЗЭЭНТ ГҮРЭН /1270 он/



ЧИН ГҮРЭН /1790 он/



ИСПАНИЙН ЗЭЭНТ ГҮРЭН /1820 он/



Эдгээр эзэнт гүрнүүд нь тухайн үедээ дэлхийн хүн амын хамгийн их хувийг эрхшээлдээ оруулсан нь аль нь байж болох вэ?

- A. Чин гүрний хүн ам: ойролцоогоор 432 сая (XVIII-р зууны байдлаар)
- B. Испанийн эзэнт гүрний хүн ам : ойролцоогоор 68 сая (XIX-р зууны байдлаар)
- C. Монголын эзэнт гүрний хүн ам: ойролцоогоор 110 сая (XIII-р зууны байдлаар)
- D. Их Британий эзэнт гүрний хүн ам: ойролцоогоор 458 сая (XX-р зууны байдлаар)


17. 1765 онд “Женна” гэдэг нэртэй нэг зэрэг найман утас ээрдэг нэхмэлийн суурь машиныг хэн зохион бүтээсэн бэ?

- A. Жон Кей B. Жеймс Харгрийвс C. Эдмунд Картрайт D. Томас Ньюкомэн

18. Техник, технологийн шинжлэх ухаанд Шведийн эрдэмтэн Альфред Нобелийн бүтээсэн бүтээлийг барилга, цэргийн салбарт ашиглах болов. Уг бүтээл нь юу байсан бэ?

- A. Унадаг дугуй B. Бордоо C. Тоосго D. Динамит

19. Доорх зурагт улаан өнгөөр будагдсан газар нутагт шашны шинэтгэх хөдөлгөөн өрнөж, ямар урсгал дэлгэрсэн бэ?



- A. Лютерийн урсгал
- B. Кальвинизм
- C. Үнэн алдартны
- D. Индульгенц

20. Түүхэн үйл явдалуудыг тохирох түүхэн зүтгэлтэнтүүдтэй нь зөв харгалзуулсан нь аль вэ?

а. 1614 онд Ерөнхий штат (Францын парламент)-ыг тараав. Тийнхүү хэмжээгүй эрхт хаант засаг тогтож, хаант төрийн гол үүрэг нь язгууртан хөрөнгөтнүүд хийгээд худалдаа аж үйлдвэрийг хөхүүлэн дэмжих болжээ.	1. Филипп
б. 1588 онд Английн эсрэг “Ялагдашгүй Армада” хэмээх 130 орчим онгоц бүхий усан флотоо илгээжээ. Гэвч тэднийг ялснаар Англи дэлхийд тэргүүлэгч далайн гүрэн болсон юм.	2. I Петр
с. 1648-1649 онд Нутгийн захиргааны чуулган хаан “Бүгд хууль”-ийг баталсан нь 1832 он хүртэл мөрдөгджээ.	3. XIII Людвик
д. 1682 онд Оросын хаан ширээнд суув. Тэрээр баруун Европын үлгэр жишээгээр улс орноо хөгжүүлэх бодлого баримталж байв. Дотоод гадаад бодлогоо шинэчлэн, Орос улс түүхийн тавцанд сэргэн босож ирэв.	4. Алексей Михайлович

A. a-1, b-2, c-3, d-4 B. a-2, b-4, c-1, d-3 C. a-4, b-3, c-1, d-2 D. a-3, b-1, c-4, d-2

21. 1755 – 1758 оны үед Манжийн эрхшээлийн эсрэг Халх Монголчуудыг удирдаж тусгаар тогтнолын төлөө тэмцсэн хүн хэн бэ?

A. Жавзандамба B. Амарсанаа C. Чингүнжав D. Тогтохтөр

22. Түүхэн сурвалж бичгүүдэд “Гар газар, хөл хөсөр” хэмээн ямар хааны үеийг тэмдэглэн бичсэн байдаг вэ?

A. Батмөнх даян хаан B. Түмэн засагт хаан
C. Тогоонтөмөр хаан D. Галдан бошгот хаан

23. Зүүнгарын сүүлчийн хаан Даваач 1755 оны 6-р сард 7000 орчим цэрэгтэйгээр Хашин нуурын дэргэд Манжийн их цэргийг хориглон байлдсан боловч давуу хүчинд цохигдон ялагджээ. Төд удалгүй 7-р сард Даваачийг барьж Бээжинд хүргүүлснээр Зүүнгарын газар нутгийг Манжийн цэрэг эзлэн авав. Уг үйл явдал хэддүгээр мянган, зуунд хамаарах вэ?

A. I-р мянганы XVIII-р зуун B. II-р мянганы XVII-р зуун
C. I-р мянганы XVII-р зуун D. II-р мянганы XVIII-р зуун

24. Батмөнх даян хааныг төр барьж байсан үеийг “Гар газар, хөл хөсөр” байсан үе хэмээдгийн учрыг зөв тайлбарласан хувилбарыг сонгоно уу.

A. Хөрш улсуудтай найрамдалт харилцаатай, худалдаа арилжаа хийж байсан үе
B. Монгол улс дотооддоо хагаралдан тэмцэлдэж, эв нэгдэлгүй байсан үе
C. Монгол улсын эдийн засаг хямралтай, ард түмэн ядуу тарчиг байсан үе
D. Монгол улс нэг хааны захиргаанд нэгдэж, дайн самуунгүй, амар тайван байсан үе

25. “...1639 онд Халхын Ширээ Цагаан нуур гэдэг газар чуулж, Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настайд нь Халх Монголын шарын шашны тэргүүн, анхдугаар Богд Жавзандамба хутагтаар өргөмжилжээ...” Халх Монгол шашны тэргүүн өргөмжилсөний үндсэн шалтгаан юу вэ?

A. Харийн соёлыг Монголд дэлгэрүүлэх
B. Монголчуудыг оюун санааны хүрээнд нэгтгэх
C. Бурхны цутгуурын урлагийг хөгжүүлэх
D. Монголчууд цэргийн хүчээ нэмэгдүүлэх